



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯМ



МОНГОЛЫН НАЦИОНАЛЫЧНЫЙ
ИНСТИТУТ



ХӨДӨЛМӨРИЙН

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2024 ОНЫ II УЛИРАЛ

Улаанбаатар хот



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯМ



ХОДОЛОГДЫН ИНСТИТУТ
ХОДОЛОГДЫН ИНСТИТУТ
ХОДОЛОГДЫН ИНСТИТУТ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2024 оны II улирал

Улаанбаатар хот

Тойм бэлтгэсэн: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ,
судалгааны институт,
Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын судалгааны сектор

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Нарны зам, 55-р байр 2 давхарт 3 тоот
Утас: (+976) 77121286
Вэб хуудас: www.institute.gov.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	3
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	6
Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд	6
Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд.....	15
Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд	20
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	23
Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ.....	23
Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах	27
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа.....	28
ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА-2023 ОН.....	32
Судалгааны танилцуулга	32
Ажиллах хүчиний нийт эрэлт	32
Ажиллах хүчиний шилжилт хөдөлгөөн	35
Ажиллах хүчиний хомсдол	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн	7
Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	11
Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар	15
Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар	17
Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгөөр	19
Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг	20
Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг	21
Хүснэгт 8. Ажил хайг болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар	23
Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар	25
Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд	26
Хүснэгт 11. Ажиллах хүчиний эрэлт, ажил мэргэжлийн ангиллын үндсэн бүлэг, хувиар	34
Хүснэгт 12. Эрэлттэй ажил мэргэжил, хувиар	34
Хүснэгт 13. Хомсдолтой ажил мэргэжил, дунд эзлэх хувь	36

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчинээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2024 оны II улирал	6
Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн	7
Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн	8
Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	9
Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	9
Зураг 6. Ажиллагчдын тоо, байршилаар, бүсээр	10
Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн	11
Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар	12
Зураг 9. Хөдөлмөрийн наслы хүн ам (15+), хөдөлмөрийн наслы хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар	12
Зураг 10. Ажиллах хүчиний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин	13
Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар	16
Зураг 12. Сайн дураар даатгуулсан малчдын тоо, мянган хүнээр, улирлаар	16
Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар	17
Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр	18
Зураг 15. YOMШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар ..	18
Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжийд хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар	20
Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар	21
Зураг 18. Ажил хайг болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар	24
Зураг 19. Ажил хайг болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дунд эзлэх хувиар	24
Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 5 улсаар, дунд эзлэх хувиар	27
Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд	28
Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 оны II улирлын байдлаар	29
Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны II улирлын байдлаар	29

Зураг 24. Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө,	30
Зураг 25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө, 2024 оны II улирлын байдлаар	31
Зураг 26. Тур ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны II улирлын байдлаар	31
Зураг 27. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллага, хувиар	32
Зураг 28. Ажиллах хүчний эрэлт, ЭЗҮА-ны салбараар, мянган хүнээр.....	33

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2024 ОНЫ II УЛИРАЛ

2024 оны II улирлын байдлаар арван тав, түүнээс дээш насны хүн амын **1 429.4** мянга (62.2хувь) нь ажиллах хүч, **868.5** мянга (37.8 хувь) нь ажиллах хүчинээс гадуурх хүн ам байна.

АЖИЛЛАХ ХҮЧ



62.2%

1 429.4 МЯНГА



94.2%
Ажиллагчид



5.8%
Ажилгүй хүн

АЖИЛЛАХ ХҮЧИНЭЭС ГАДУУРХ



37.8%

868.5 МЯНГА

34.2%
Тэтгэвэрт

32.9%
Суралцдаг

32.9%
Бусад

АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүн

2023 II 53.9%

46.1% 1 279.1

5.3%

2024 II 54.4%

45.6% 1 347.1

Өмнөх оны мөн үеэс

ХАМГИЙН ИХ АЖИЛЛАГЧИДТАЙ З САЛБАР



325.4 мянга (24.2%)

Хөдөө аж ахуй, ойн аж ахуй,
загас барилт, ан агуулр

59.7%

194.3 мянга



40.3%

131.1 мянга



197.6 мянга (14.7%)

Бөөний болон жижиглэн худалдаа,
машин, мотоциклийн завсрал, үйлчилгээ

42.2%

83.3 мянга



57.8%

114.3 мянга



131.8 мянга (9.8%)

Боловсрол

23.7%

31.2 мянга



76.3%

100.5 мянга

АЖИЛГҮЙ ИРГЭД

2023 II 61.2%

38.8%

76.2 мянга

8.0%

Өмнөх оны мөн үеэс

2024 II 57.9%

42.1%

82.3 мянга


Мэдээллийн эх үүсвэр: www.i212.mn

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд

Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2024 оны II улирлын дүнгээс харахад арван тав, түүнээс дээш насны хүн 2297.9 мянга, үүнээс 1429.4 мянга (62.2 хувь) нь ажиллах хүч, 868.5 мянга (37.8 хувь) нь ажиллах хүчинээс гадуурх хүн ам байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 25.4 мянга буюу 1.1 хувиар нэмэгдсэн бол өмнөх улирлаас 0.2 мянга буюу 0.01 хувиар буурсан байна.

Нийт ажиллах хүчиний 54.6 хувь нь эрэгтэйчүүд, 45.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин ажиллах хүчинээс гадуурх хүн амын 37.7 хувь нь эрэгтэйчүүд, 62.3 хувь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Ажиллах хүч, ажиллах хүчинээс гадуурх хүн амын тоо, мянган хүн, 2024 оны II улирал



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 74.1 мянгаар, өмнөх улирлаас 25.1 мянгаар өссөн байна.

Ажиллах хүчиний 1347.1 мянга (94.2 хувь) нь ажиллагчид, 82.3 мянга (5.8 хувь) нь ажилгүйчүүд байна. Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 68.0 мянгаар (5.3 хувь), өмнөх улирлаас 14.5 мянгаар (1.1 хувь) өссөн бол ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 6.1 мянгаар (8.0 хувь), өмнөх улирлаас 10.5 мянгаар (14.7 хувь) өссөн байна.

Ажиллах хүчинээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 48.7 мянга буюу 5.3 хувиар, бусад ажиллах хүчинээс гадуурх хүн ам 48.5 мянга буюу 5.5 хувиар, боломжит ажиллах хүч 0.2 мянга буюу 0.8 хувиар буурсан байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам 2024 оны II улирлын байдлаар улсын хэмжээнд 117.3 мянга болж өмнөх оны мөн үеэс 6.1 мянгаар (5.5 хувь) өссөн бол өмнөх улирлаас 0.3 мянгаар (0.2 хувь) буурсан байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүтцээр нь авч үзвэл, 82.3 мянга (70.2 хувь) нь ажилгүй хүн, 27.8 мянга (23.7 хувь) нь боломжит ажиллах хүч, 7.2 мянга (6.1 хувь) нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч байна.

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өссөн бол өмнөх улирлаас 24.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд, мянган хүн

Үзүүлэлт	2023				2024			Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	II	он	улирал	
Ажиллах хүч	1,341.0	1,355.3	1,400.1	1,375.6	1,404.4	1,429.4	74.1	25.1	
Үүнээс: эмэгтэй	621.0	619.6	630.2	624.0	642.7	648.6	29.0	5.9	
Ажиллагчид	1,253.9	1,279.1	1,326.2	1,322.2	1,332.6	1,347.1	68.0	14.5	
Үүнээс: эмэгтэй	587.8	590.0	599.5	605.2	612.4	613.9	23.9	1.5	
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.2	7.0	7.3	6.3	9.5	7.2	0.2	-2.3	
Үүнээс: эмэгтэй	2.9	5.3	5.1	3.7	5.9	4.5	-0.8	-1.4	
Ажилгүй хүн	87.2	76.2	73.9	53.3	71.8	82.3	6.1	10.5	
Үүнээс: эмэгтэй	33.2	29.6	30.7	18.9	30.3	34.7	5.1	4.4	
Ажиллах хүчинээс гадуурх хүн ам	931.0	917.2	872.4	896.9	893.7	868.5	-48.7	-25.2	
Үүнээс: эмэгтэй	563.1	562.1	562.2	567.8	547.0	541.4	-20.7	-5.6	
Боломжит ажиллах хүч	32.4	28.0	43.6	53.3	36.3	27.8	-0.2	-8.5	
Үүнээс: эмэгтэй	16.5	15.4	30.2	27.7	16.1	13.8	-1.6	-2.3	
Бусад ажиллах хүчинээс гадуурх хүн ам	898.6	889.1	828.8	843.5	857.4	840.6	-48.5	-16.8	
Үүнээс: эмэгтэй	546.6	546.7	532.0	540.0	530.9	527.6	-19.1	-3.3	
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	125.8	111.2	124.7	112.9	117.6	117.3	6.1	-0.3	
Үүнээс: эмэгтэй	52.6	50.3	66.0	50.3	52.2	53.0	2.7	0.8	

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоо 2024 оны II улиралд 1347.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 68.0 мянгаар, өмнөх улирлаас 14.5 мянгаар ёссэн байна.

Зураг 2. Ажиллагчид, ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2024 оны II улиралд ажил хөдөлмөр эрхэлж байгаа 100 хүн тутмын 48 нь (48.7 хувь) хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсролын салбарт ажиллаж байна. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбар нь хөдөлмөр эрхлэлтийн дөрөвний нэг (24.2 хувь)-ийг бүрдүүлдэг хамгийн том салбар хэвээр байна.

Зураг 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо өссөн салбарууд: бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 46.6 мянгаар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 14.9 мянгаар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал 13.6 мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 13.3 мянгаар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 7.8 мянгаар, боловсрол 7.1 мянгаар, боловсруулах үйлдвэрлэл 6.4 мянгаар, уул уурхай олборлолт 5.6 мянгаар, барилга 5.4 мянгаар, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа 4.8 мянгаар, ургал, үзүүр, тоглоом, наадам 1.9 мянгаар, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа 1.7 мянгаар, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 0.1 мянгаар тус тус нэмэгджээ.

Харин өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо буурсан салбарууд: хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт 42.0 мянгаар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 8.3 мянгаар, усан хангамж, бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 5.1 мянгаар, цахилгаан, хий, уур, агааржуулалт 2.7 мянгаар, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 1.2 мянгаар, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа 0.8 мянгаар, мэдээлэл холбоо 0.8 мянгаар, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа 0.2 мянгаар тус тус бүр буурсан байна.


Зураг 4. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбар, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын тоог хүйсээр харвал өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуйн салбарын эрэгтэй ажиллагчдын тоо 9.3 мянгаар буурсан бол эмэгтэй ажиллагчдын тоо 8.2 мянгаар нэмэгдсэн байна. Үйлдвэрлэлийн салбарт эрэгтэй ажиллагчдын тоо 11.6 мянгаар нэмэгдсэн бол эмэгтэй ажиллагчдын тоо 9.3 мянгаар буурсан байна. Харин үйлчилгээний салбарт эмэгтэй ажиллагчдын тоо 14.1 мянгаар буурсан бол эрэгтэй ажиллагчдын тоо 14.7 мянгаар өссөн байна.


Зураг 5. Ажиллагчдын тооны өөрчлөлт, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн 3 салбараар, хүйсээр, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын 617.4 мянга (45.8 хувь) нь Улаанбаатар хотод, 729.7 мянга (54.2 хувь) нь хөдөө, орон нутагт байна. Ажиллагчдыг бүсээр авч үзвэл 262.6 мянга (19.5 хувь) нь Хангайн бүсэд, 189.8 мянга (14.1 хувь) нь Төвийн бүсэд, 174.0 мянга (12.9 хувь) нь Баруун бүсэд, 103.3 мянга (7.7 хувь) нь Зүүн бүсэд байна. Ажиллагчдын тооны өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хот 71.2 мянгаар (13.0 хувь), Зүүн бүс 1.5 мянгаар (1.5 хувь) өссөн бол Баруун бүс 3.7 мянгаар (2.1 хувь), Төвийн бүс 0.7 мянгаар (0.4 хувь), Хангайн бүс 0.2 мянгаар (0.1 хувь) өссөн байна.

Зураг 6. Ажиллагчдын тоо, байршилаар, бүсээр



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо


2024 оны II улирлын байдлаар ажилгүй иргэдийн 47.6 мянга (57.9 хувь) нь эрэгтэй, 34.7 мянга (42.1 хувь) нь эмэгтэйчүүд байна.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 6.1 мянга буюу 8.0 хувиар өсжээ. Үүнд ажилгүй эрэгтэйчүүд 1.0 мянга буюу 2.2 хувиар, эмэгтэйчүүд 5.1 мянга буюу 17.2 хувиар өссөн байна.

Ажилгүйчүүдийн тоог бүсээр авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 47.9 хувь нь, Хангайн бүсэд 19.2 хувь нь, Баруун бүсэд 14.9 хувь нь, Төвийн бүсэд 13.2 хувь нь, Зүүн бүсэд 4.7 хувь нь байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар 8.3 мянгаар, Хангайн бүс 3.3 мянгаар, Зүүн бүс 0.7 мянгаар бол Төвийн бүс 4.8 мянгаар, Баруун бүс 1.4 мянгаар ажилгүй иргэд буурчээ.

Мөн ажилгүйчүүдийн тоог насны бүлгээр авч үзвэл 21.9 мянга (26.6 хувь) нь 15-24 насны, 21.9 мянга (26.6 хувь) нь 25-34 насны, 24.7 мянга (30.1 хувь) нь 35-44 насны, 9.9 мянга (12.1 хувь) нь 45-54 насны, 3.9 мянга (6.9 хувь) нь 55, түүнээс дээш насны хүн байна. Ажилгүйчүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25-34 насны залуучууд 1.0 мянгаар, 35-44 насны иргэд 4.4 мянгаар өссөн бол 45-54 насны ажилгүй иргэд 2.8 мянгаар буурсан байна.

Зураг 7. Ажилгүй хүний тоо, өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс, мянган хүн



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 2. Ажилгүй хүний тоо, улирлаар, мянган хүн

Үзүүлэлт	2023				2024				Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	II	Он	Улирал		
Бүгд	87.2	76.2	73.9	53.3	71.8	82.3	6.1	10.5		
Хүйсээр	Эрэгтэй	53.9	46.6	43.2	34.4	41.4	47.6	1.0	6.2	
	Эмэгтэй	33.2	29.6	30.7	18.9	30.3	34.7	5.1	4.4	
Насны бүлэгээр	15-24	14.1	18.4	17.7	12.4	12.2	21.9	3.5	9.7	
	25-34	25.3	20.8	20.1	14.2	22.1	21.9	1.1	-0.2	
	35-44	24.6	20.4	21.3	12.6	21.2	24.7	4.3	3.5	
	45-54	18.7	12.8	11.0	9.8	12.5	9.9	-2.9	-2.6	
	55+	4.5	3.8	3.9	4.3	3.8	3.9	0.1	0.1	
Бүсээр	Баруун бүс	11.6	13.7	11.7	6.7	13.1	12.3	-1.4	-0.8	
	Хангайн бүс	20.8	12.5	16.3	13.4	18.1	15.8	3.3	-2.3	
	Төвийн бүс	12.3	15.7	15.2	10.3	11.2	10.9	-4.8	-0.3	
	Зүүн бүс	3.5	3.1	5.1	3.7	4.4	3.9	0.8	-0.5	
Улаанбаатар	39.0	31.2	25.5	19.3	24.9	39.4	8.2	14.5		

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйчүүдийг боловсролын түвшнээр ангилбал 0.7 хувь нь магистр, 32.4 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 4.2 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 28.6 техникийн болон мэргэжлийн 20.2 хувь нь бүрэн дунд, 10.2 хувь нь суурь, 1.9 хувь нь бага, 1.9 хувь нь боловсролгүй иргэд байна.

Зураг 8. Ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, хувиар




НЬ **Дипломын дээд болон
бакалаврас** дээш
боловсролтой байна.



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 5.8 хувь болж, өмнөх улирлаас 0.7 пункттээр өмнөх оны мөн үеэс 0.2 пункттээр өссөн байна. Энэ хугацаанд эмгэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 5.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.5 пункттээр өссөн бол эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 6.1 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.2 мөн пункттээр буурсан байна. Насны булгээр харвал 25-29 насны залуучууд 4.7 хувь буюу өмнөх улирлаас 0.4 хувиар буурсан бол 35-39 насны иргэд 2.2 хувиар өссөн байна.

Зураг 9. Хөдөлмөрийн насны хүн ам (15+), хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчиний нийлүүлэлтийн эзлэх хувийг илрхийлэх түвшин бүхий ажиллах хүчиний оролцооны түвшинг улирлаар авч үзэхэд 2024 оны II улиралд 62.2 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.6 пункттээр, өмнөх улирлаас 1.1 пункттээр өссөн байна.

Хөдөлмөрийн нөөцэд ажиллагчдын эзлэх хувь буюу хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2024 оны II улирлын байдлаар 58.6 хувь болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 пунктээр өссөн байна.

Зураг 10. Ажиллах хүчиний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2024 ОНЫ II УЛИРАЛ

ШИМТГЭЛ ТӨЛӨГЧ ААНБ

2023 II
улирал

54 405



2024 II
улирал

53 075

↓ 2.4% Өмнөх оны мөн үеэс

ТЭТГЭВЭР АВАГЧИД

2023 II улирал

484.9
мянга

500.6
мянга



↑ 3.2%
Өмнөх оны
мөн үеэс



79.0%
Өндөр насны тэтгэвэр



4.0%
Тэжээгчээ алдсаны
тэтгэвэр



12.7%
Хөдөлмөрийн чадвар
алдсаны тэтгэвэр



4.3%
Цэргийн тэтгэвэр

ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

Тэтгэвэр
82.7%
1662.1 тэрбум

Тэтгэмж
8.7%
175.7 тэрбум




Ажилгүйдэл
3.1%
62.6 тэрбум

ҮОМШӨ*
5.5%
109.5 тэрбум

ДААТГУУЛАГЧ

2023 II улирал



1061.1 мянга

↓ 12.6%

Өмнөх оны
мөн үеэс

2024 II улирал



927.4 мянга

Даатгуулагчид, төрлөөр

Албан журам



89.8%
832.7 мянга

Сайн дур



10.2%
94.7 мянга

САЙН ДУРААР ДААТГУУЛАГЧ

33.4% Малчид

31.6 мянга

↑ 2.1 дахин
Өмнөх оны
мөн үеэс

ЗАРЛАГА

Тэтгэвэр
91.8%
2235.9 тэрбум



Ажилгүйдэл
2.6%
62.1 тэрбум

ҮОМШӨ*
0.9%
22.5 тэрбум

Мэдээллийн эх үүсвэр: НДЕГ



www.institute.gov.mn



(976)-77121286



https://info@institute.gov.mn



<https://www.facebook.com/institute.gov.mn>

Нийгмийн даатгалын үзүүлэлтүүд

Нийгмийн даатгалын сангийн 2008-2022 оны төсвийн тухай хуулиудаар нийгмийн даатгалын санд төвлөрүүлэх орлогын хэмжээг батлахдаа ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг “Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл”, “Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл” гэсэн орлогын төрлөөр тус тусад нь баталж байсныг Нийгмийн даатгалын сангийн 2023, 2024 оны төсвийн тухай хуулиудаар зөвхөн “ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл” гэж өөрчлөн баталсан.

2024 оны II улирлын байдлаар шимтгэл төлөгч байгууллагын тоо 53.1 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.3 мянга буюу 2.4 хувиар буурсан байна.

Мөн 2024 оны II улирлын байдлаар нийгмийн даатгалд 927.4 мянган даатгуулагч даатгуулсан бөгөөд 94.7 мянга (10.2 хувь) нь сайн дурын, 832.7 мянга (89.8 хувь) нь албан журмын даатгуулагч байна. Даатгуулагчийн тоо өмнөх оны мөн үеэс 133.7 мянга буюу 12.6 хувиар буурсан байна.

Албан журмын даатгуулагч өмнөх оны мөн үеэс 98.5 мянга буюу 10.6 хувиар, сайн дурын дурын даатгуулагч 35.2 мянга буюу 27.1 хувиар тус тус буурсан дүнтэй байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалд шимтгэл төлөгч байгууллага, даатгуулагч, улирлаар

Улирал	Шимтгэл төлөгч ААНБ	Даатгуулагч		
		Нийт	Сайн дур	Албан журам
2020 I	42,862	831,943	108,042	723,901
II	46,762	961,692	156,624	805,068
III	47,818	1,051,309	172,892	878,417
IV	49,067	1,156,793	192,090	964,703
2021 I	46,242	845,802	100,956	744,846
II	48,738	962,387	136,141	826,246
III	50,625	1,062,030	147,827	914,203
IV	52,388	1,181,282	161,111	1,020,171
2022 I	48,462	891,825	107,417	784,354
II	51,776	1,029,922	133,167	896,755
III	53,425	1,141,946	146,833	995,113
IV	55,121	1,274,588	162,414	1,112,174
2023 I	51,282	925,215	108,644	816,571
II	54,405	1,061,097	129,881	931,216
III	56,057	1,175,543	142,159	1,033,384
IV	58,908	1,315,989	158,588	1,157,401
2024 I	49,329	860,181	56,135	804,046
II	53,075	927,414	94,686	832,728

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Зураг 11. Даатгуулагчийн тоо, төрөл, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сайн дурын даатгуулагчдын 31.6 мянга (33.4 хувь) нь малчид, үлдсэн 63.1 мянга (66.6 хувь) нь бусад төрлийн даатгуулагч байна. Даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оны мөн үеэс 16.7 мянга буюу 2.1 дахин өссөн байна.

Зураг 12. Сайн дураар даатгуулсан малчдын тоо, мянган хүнээр, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Тэтгэврийн даатгалын сангасаас тэтгэвэр авсан иргэд 2024 оны II улирлын байдлаар 500.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 15.6 мянга буюу 3.2 хувиар нэмэгджээ. Тэтгэвэр авсан иргэдийн 79.0 хувь нь өндөр насны тэтгэвэр, 12.7 хувь нь хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, 4.0 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 4.3 хувь цэргийн тэтгэвэр авсан байна.

Өндөр насны тэтгэвэр авсан иргэд 2024 оны II улирлын байдлаар 395.4 мянга болж, өмнөх оны мөн үеэс 14.5 мянга буюу 3.8 хувиар, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авсан иргэд 20.1 мянга болж 257 буюу 1.3 хувиар, цэргийн тэтгэвэр авсан иргэд 21.7 мянга болж 499 буюу 2.4 хувиар, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр¹ авсан иргэд 63.5 мянга болж 279 буюу 0.4 хувиар нэмэгдсэн.


¹ "Тахир дуттугийн тэтгэвэр" гэсэн нэршилгийг 2024.01.01-ээс мөрдж байгаа "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга"-д нийцүүлэн "Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр" болгон өөрчилсөн.

Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэдийн тоо, төрөл, улирлаар


Улирал	Тэтгэвэр авагчдын тоо	Үүнээс:			
		Өндөр насны тэтгэвэр	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	Цэргийн тэтгэвэр
2020 I	427,247	320,602	67,912	19,853	18,880
II	434,186	327,799	67,663	19,711	19,013
III	439,481	333,026	67,769	19,584	19,102
IV	444,788	338,982	67,018	19,553	19,235
2021 I	449,419	344,287	66,344	19,511	19,277
II	451,845	347,235	65,771	19,377	19,462
III	454,298	350,091	65,197	19,437	19,573
IV	456,365	353,775	63,318	19,563	19,709
2022 I	462,607	359,783	63,439	19,588	19,797
II	467,420	364,173	63,491	19,625	20,131
III	471,387	368,050	63,280	19,705	20,424
IV	476,446	373,209	62,702	19,743	20,792
2023 I	480,312	376,643	63,097	19,744	20,828
II	484,981	380,843	63,133	19,850	21,155
III	488,366	384,043	63,117	19,969	21,237
IV	493,038	388,345	63,305	20,008	21,380
2024 I	496,669	391,819	63,302	20,079	21,469
II	500,560	395,387	63,412	20,107	21,654

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Зураг 13. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авсан иргэд, төрлөөр, хувиар



- Өндөр насны тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Цэргийн тэтгэвэр



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэд 2024 оны II улирлын байдлаар 74.6 мянга болж, өмнөх оны мөн үеэс 35.9 мянга буюу 32.5 хувиар буурсан байна. Тэтгэмж авсан иргэдийн 57.7 хувь нь хөдөлмөрийн чадвар тур алдсаны тэтгэмж, 32.9 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж, 9.4 хувь нь нас барсан даатгуулагчийн гэр булийн гишүүнд олгох тэтгэмж² авсан байна.

² “ОРШУУЛГЫН ТЭТГЭМЖ” ГЭСЭН НЭРШЛИЙГ “НАС БАРСАН ДААТГУУЛАГЧИЙН ГЭР БУЛИЙН ГИШҮҮНД ОЛГОХ ТЭТГЭМЖ” БОЛГОН ӨӨРЧИЛСЕН.¹⁷


Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан иргэд 2024 оны II улирлын байдлаар 43.0 мянга болж, өмнөх оны мэн үеэс 40.9 хувиар, жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсан иргэд 24.6 мянга болж өмнөх оны мэн үеэс 19.8 хувиар бурсан бол нас барсан даатгуулагчийн гэр булийн гишүүнд олгох тэтгэмж авсан иргэд 6.9 мянга болж, өмнөх оны мэн үеэс 0.2 хувиар ёссөн байна.

Зураг 14. Тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авсан иргэдийн тоо, төрлөөр

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж



Жирэмсний болон амаржсаны тэтгэмж




Нас барсан даатгуулагчийн гэр булийн гишүүнд олгох тэтгэмж



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд 2024 оны II улирлын байдлаар 5.3 мянга болж, өмнөх оны мэн үеэс 35 буюу 0.7 хувиар ёссөн байна. YOMШӨ-ны даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэдийн 65.0 хувь нь тахир дутуугийн тэтгэвэр, 8.6 хувь нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 17.4 хувь нь эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр³, 9.0 хувь нь тэтгэмж, төлбөрт хамрагдсан байна.

Зураг 15. YOMШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан иргэд, төрлөөр, хувиар



- Тахир дутуугийн тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
- Тэтгэмж, төлбөр
- Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

³ "YOMШӨ-ний сувилал" гэсэн нэршилийг "Эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр" болгон өөрчилсөн.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2024 оны II улирлын байдлаар 2009.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 422.1 тэрбум төгрөг буюу 26.6 хувиар, нийгмийн даатгалын зарлага 2434.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 661.6 тэрбум төгрөг буюу 37.3 хувиар нэмэгдсэн.

2024 оны II улирлын байдлаар шимтгэлийн орлогын 82.7 хувийг тэтгэврийн даатгалын сан, 8.7 хувийг тэтгэмжийн даатгалын сан, 5.5 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 3.1 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна. Харин нийгмийн даатгалын зарлагын 91.8 хувийг тэтгэврийн даатгалын сан, 4.7 хувийг тэтгэмжийн даатгал сан, 0.9 хувийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан, 2.6 хувийг ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, тэрбум төгрөгээр

Үзүүлэлт	2023 II	Эзлэх хувь	Өөрчлөлт			
			2024 II	Эзлэх хувь	Тоо	Хувь
НД-ын сангийн орлого	1587.7	100.0%	2009.9	100.0%	422.1	26.6%
Тэтгэвэр	1318.3	83.0%	1662.1	82.7%	343.8	26.1%
Тэтгэмж	135.0	8.5%	175.7	8.7%	40.7	30.1%
ҮОМШӨ	108.4	6.8%	109.5	5.5%	1.1	1.0%
Ажилгүйдэл	26.0	1.6%	62.6	3.1%	36.6	140.8%
НД-ын сангийн зарлага	1772.9	100.0%	2434.6	100.0%	661.6	37.3%
Тэтгэвэр	1604.2	90.5%	2235.9	91.8%	631.7	39.4%
Тэтгэмж	99.9	5.6%	114.1	4.7%	14.2	14.2%
ҮОМШӨ	16.8	0.9%	22.5	0.9%	5.7	33.9%
Ажилгүйдэл	51.9	2.9%	62.1	2.6%	10.2	19.7%

Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажилгүйдлийн тэтгэмжид 2024 оны II улирлын байдлаар 12.5 мянган иргэн хамрагдсан бөгөөд тэтгэмж болгож 62.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 3.3 мянга буюу 20.6 хувиар буурч, тэтгэмжид зарцуулсан хөрөнгө 10.1 тэрбум төгрөг буюу 19.5 хувиар нэмэгджээ.

2023 оны II улиралд ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан нэг хүнд дунджаар 3.3 сая төгрөгийг зарцуулж байсан бол 2024 оны II улиралд 5.0 сая болж, 51.6 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 16. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдсан хүн, зарцуулсан хөрөнгө, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Сарын дундаж цалингийн үзүүлэлтүүд

Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2024 оны II улирлын байдлаар 2464.9 мянга болж, өмнөх оны мөн үеэс 574.9 мянга буюу 30.4 хувиар, өмнөх улирлаас 181.2 мянга буюу 7.9 хувиар өссөн байна. Тухайн өсөлт нь нэрлэсэн дундаж цалингийн өсөлт бөгөөд бодит цалиниийн өсөлт биш юм.

Ажиллагчдын сарын дундаж цалинг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүд 2716.7 мянган төгрөг, эмэгтэйчүүд 2200.0 мянган төгрөгийн цалинтай байна. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн цалингийн зөрүү 2024 оны II улиралд 516.7 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 95.9 мянгар өссөн байна.

Өөрөөр хэлбэл 2024 оны II улирлын байдлаар эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийн дундаж цалингийн 81.1 хувьтай тэнцэж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр өссөн нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн цалингийн ялгаа өсөж байгааг харуулж байна.

Хүснэгт 6. Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, мянган төгрөг

Үзүүлэлт	2023				2024				Өөрчлөлт	
	I	II	III	IV	I	II	III	IV	Он	Улирал
Дундаж цалин	1,830.8	1,890.0	2,009.3	2,235.4	2,283.7	2,464.9	574.9	181.2		
Эрэгтэй	2,044.2	2,096.4	2,275.4	2,479.8	2,568.4	2,716.7	620.3	148.3		
Эмэгтэй	1,610.9	1,675.6	1,737.9	1,979.1	1,987.8	2,200.0	524.4	212.2		

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Медиан цалин гэдэг ажиллагчдын цалинг өсөх эсвэл буурах эрэмбээр байршуулсан цувааг таллан хувааж байгаа ажилтны цалин юм. 2024 оны II улирлын байдлаар медиан цалин 2027.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 591.8 мянган төгрөгөөр буюу 41.2 хувиар, өмнөх улирлаас 228.3 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна.

2024 оны II улирлын байдлаар нийгмийн даатгалд шимтгэл төлсөн ажиллагчдыг цалин хөлсний бүлгээр авч үзвэл 420.0 мянгаас 700.0 мянган төгрөгийн цалинтай 10.2 хувь, харин 2.0 саяас 3.0 сая төгрөгийн цалинтай ажиллагчдын эзлэх хувь 26.6 хувь байна.

Зураг 17. Дундаж болон медиан цалин, мянган төгрөг, улирлаар



Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

2024 оны II улирлын байдлаар 1-9 ажиллагчидтай байгууллагын дундаж цалин улсын дунджаас 1039.4 мянгаар, 10-49 ажиллагчидтай байгууллагынх 386.2 мянгаар, 50-99 ажиллагчидтай байгууллагынх 76.3 мянгаар бага байгаа бол 100-199 ажиллагчидтай байгууллагынх 109.0 мянгаар, 200 түүнээс дээш ажиллагчидтай байгууллагынх 840.0 мянган төгрөгөөр өндөр байна.

Дундаж цалингийн өөрчлөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 200 дээш ажиллагчидтай байгууллагын ажиллагчдын дундаж цалин хамгийн их буюу 655.7 мянган төгрөг (24.8 хувиар)-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Ажиллагчдын сарын дундаж цалин, ажиллагчдын тооны бүлэг, хүйсээр, мянган төгрөг

Ажиллагчдын тооны бүлэг	2023 II			2024 II			Өөрчлөлт	
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Toо	Хувь
Бүгд	1,890.00	2,096.40	1,675.60	2,464.90	2,716.68	2,200.00	574.9	30.42%
1-9	1,129.60	1,130.50	1,128.70	1,425.50	1,424.61	1,426.30	295.9	26.20%
10-49	1,505.20	1,539.30	1,475.40	2,078.70	2,086.77	2,071.60	573.5	38.10%
50-99	1,759.40	1,857.20	1,669.40	2,388.60	2,514.40	2,276.40	629.2	35.76%
100-199	1,950.50	2,091.30	1,807.10	2,573.90	2,738.40	2,404.10	623.4	31.96%
200 дээш	2,649.20	3,023.60	2,148.00	3,304.90	3,773.73	2,646.50	655.7	24.75%

Мэдээллийн эх үүсвэр: www.1212.mn, Үндэсний статистикийн хороо

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын цалин хамгийн их буюу 5.1 сая төгрөг, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт хамгийн бага буюу 1.5 сая төгрөг байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ-2024 ОНЫ II УЛИРАЛ

АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН



9 563



45.8%
Эмэгтэй



2.6%
Хөгжлийн
бэрхшээлтэй

АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА



53 198



26.2%
Эрэлт хангасан хувь

↑ 3.1 дахин
Өмнөх оны
мөн үеэс

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭН



7 681



46.5%
Эмэгтэй



2.5%
Хөгжлийн
бэрхшээлтэй

АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭН



13 964



46.7%
Эмэгтэй

↑ 70.3%
Өмнөх оны мөн үеэс

Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, улсаар

15 609

Гадаадын иргэд




= 14 410 (92.3%)

Эрэгтэй



1 199 (7.7%)

Эмэгтэй



Мэдээллийн эх үүсвэр: ХХҮЕГ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ УЙЛ АЖИЛЛАГАА

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэдийн тоо 2024 оны II улирлын байдлаар 9.6 мянга (үүний 3.3 мянга буюу 45.8 хувь нь эмэгтэй) байна. Насны бүлгээр авч үзвэл, 1.1 мянга (11.4 хувь) нь 15-24 наасны, 2.9 мянга (30.3 хувь) нь 25-34 наасны, 2.9 мянга (30.4 хувь) нь 35-44 наасны, 1.9 мянга (20.2 хувь) нь 45-54 наасны, 0.7 мянга (7.7 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.


Харин тухайн үед ажилгүй байгаа, ажил идэвхтэй хайж хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн бүртгэлтэй ажилгүй иргэн 7.7 мянга байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 4.1 мянга (53.5 хувь) нь эрэгтэйчүүд, 3.6 мянга (46.5 хувь) нь эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзвэл, 0.8 мянга (10.8 хувь) нь 15-24 наасны, 2.4 мянга (31.5 хувь) нь 25-34 наасны, 2.4 мянга (30.8 хувь) нь 35-44 наасны, 1.5 мянга (19.4 хувь) нь 45-54 наасны, 0.6 мянга (7.5 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

Хүснэгт 8. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар

Улирал	Ажил хайгч /сарын эцэст/	Бүртгэлтэй ажилгүй иргэн				
		Эмэгтэй	Эзлэх хувь	/сарын эцэст/	Эмэгтэй	Эзлэх хувь
2020 I	31,785	16,285	51.2%	19,394	10,009	51.6%
II	30,320	15,367	50.7%	19,563	10,001	51.1%
III	27,504	14,301	52.0%	17,829	9,446	53.0%
IV	29,952	15,390	51.4%	18,103	9,535	52.7%
2021 I	25,105	12,774	50.9%	16,775	8,650	51.6%
II	26,991	13,837	51.3%	17,650	9,202	52.1%
III	21,804	11,316	51.9%	15,053	7,895	52.4%
IV	27,950	14,510	51.9%	18,644	9,821	52.7%
2022 I	24,255	12,019	49.6%	16,622	8,345	50.2%
II	24,184	12,075	49.9%	16,282	8,210	50.4%
III	19,832	10,609	53.5%	13,545	7,389	54.8%
IV	21,256	11,069	52.1%	13,966	7,326	52.4%
2023 I	14,246	7,238	50.7%	9,069	4,651	51.1%
II	5,737	2,954	51.5%	4,323	2,265	52.4%
III	6,224	3,372	54.2%	4,655	2,568	55.2%
IV	11,662	6,308	54.1%	8,813	4,784	54.3%
2024 I	6,896	3,303	47.9%	5,494	2,590	47.1%
II	9,563	4,384	45.8%	7,681	3,570	46.5%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Зураг 18. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, сарын эцэст, улирлаар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Ажил хайгч иргэдийн боловсролын түвшинг авч үзвэл, 1.6 хувь нь боловсролгүй, 5.4 хувь нь бага, 10.0 хувь нь суурь, 46.5 хувь нь бүрэн дунд, 7.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 23.0 дипломын дээд болон бакалавр, 1.6 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл, 1.8 хувь нь боловсролгүй, 5.6 хувь нь бага, 9.7 хувь нь суурь, 45.2 хувь нь бүрэн дунд, 7.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 24.5 хувь нь дипломын дээд болон бакалавр, 1.4 хувь нь магистр, түүнээс дээш түвшний боловсролтой байна.

Зураг 19. Ажил хайгч болон бүртгэлтэй ажилгүй иргэн, боловсролын түвшин, дунд эзлэх хувиар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2024 оны II улиралд 53.2 мянган ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 14.0 мянган иргэнийг ажилд зуучилж, эрэлтийн 26.2 хувийг хангажээ. Ажлын байрны захиалга өмнөх оны мөн үеэс 36.3 мянга буюу 3.1 дахин, ажилд зуучлагдсан иргэд өмнөх оны мөн үеэс 5.8 мянга буюу 70.3 хувиар нэмэгдсэн байна.

Ажилд зуучлагдсан иргэдийг насны булгээр авч үзвэл, 2.3 мянга (16.7 хувь) нь 15-24 насны, 3.9 мянга (28.2 хувь) нь 25-34 насны, 3.6 мянга (26.1 хувь) нь 35-44 насны, 2.7 мянга (19.0 хувь) нь 45-54 насны, 1.4 мянга (10.0 хувь) нь 55, түүнээс дээш насныхан байна.

2024 оны II улиралд хөдөлмөрийн эрэлтийн 26.2 хувийг хангасан бөгөөд өмнөх оны мөн үеэс 22.1 пункттээр, өмнөх улирлаас 2.1 пункттээр буурсан байна.

Хүснэгт 9. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэн, улирлаар

Улирал	Ажлын байрны захиалга	Ажилд зуучлагдсан иргэн	Эмэгтэй	Эзлэх хувь	Эрэлт хангасан хувь
2020 I	7,595	4,489	2,307	51.4%	59.1%
II	28,036	15,250	7,330	48.1%	54.4%
III	42,433	21,672	10,858	50.1%	51.1%
IV	58,022	33,006	16,651	50.4%	56.9%
2021 I	6,413	3,066	1,545	50.4%	47.8%
II	20,352	11,416	5,542	48.5%	56.1%
III	32,656	17,636	9,068	51.4%	54.0%
IV	51,034	29,929	15,460	51.7%	58.6%
2022 I	9,322	3,901	2,003	51.3%	41.8%
II	24,320	13,670	6,709	49.1%	56.2%
III	32,972	18,897	9,499	50.3%	57.3%
IV	55,211	32,290	16,412	50.8%	58.5%
2023 I	4,863	2,267	1,066	47.0%	46.6%
II	16,950	8,199	4,149	50.6%	48.3%
III	50,222	16,656	8,660	51.2%	33.2%
IV	84,870	35,281	18,903	53.6%	41.6%
2024 I	17,435	4,930	2,486	50.4%	28.3%
II	53,198	13,964	6,521	46.7%	26.2%

Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл, 2024 оны II улиралд ирсэн ажлын байрны захиалгын 9.5 мянга нь боловсруулах үйлдвэрлэл (17.9 хувь), 7.4 мянга нь хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (13.9 хувь), 5.9 мянга нь уул уурхай, олборлолт (11.1 хувь)-ын салбараас ирсэн байна.

2024 оны II улирлын байдлаар ус хангамж, бохир ус зайлцуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, боловсрол, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын 21.2-47.7 хувийг, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, уул уурхай, олборлолт, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, баөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар, үйлчилгээ, боловсруулах үйлдвэрлэл, санхүүгийн болон даатгалын үйл

ажиллагаа, мэдээлэл, холбооны салбарын 13.5-36.0 хувийг, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, барилга, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа, цахилгаан, хий, уур, агааржуулалт, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын эрэлтийн 4.3-59.4 хувийг хангасан байна.

Хүснэгт 10. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд

Үзүүлэлт	Ажлын байрны захиалга	Эзлэх хувь	Ажилд зуучлагдсан иргэн	Эзлэх хувь	Эрэлт хангасан хувь
Бүгд	53,198	100.00%	13,964	100.00%	26.2
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агуунур	7,421	13.95%	2315	16.58%	31.2
Уул урхай, олборлолт	5,914	11.12%	1270	9.09%	21.5
Боловсруулах үйлдвэрлэл	9,527	17.91%	2103	15.06%	22.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	180	0.34%	107	0.77%	59.4
Ус хангамж, бокир ус зайлцуулах систем, хог хаягдал	3916	7.36%	1209	8.66%	30.9
Барилга	4,883	9.18%	610	4.37%	12.5
Бөөний болон жижиглэн худалдаа	3,893	7.32%	1274	9.12%	32.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1386	2.61%	367	2.63%	26.5
Зочид будал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	1158	2.18%	417	2.99%	36.0
Мэдээлэл, холбоо	313	0.59%	61	0.44%	19.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	274	0.52%	81	0.58%	29.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	20	0.04%	4	0.03%	20.0
Мэргэжлийн ШУ болон техникийн үйл ажиллагаа	371	0.70%	60	0.43%	16.2
Үдирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	3688	6.93%	498	3.57%	13.5
Төрийн үдирдлага ба батлан хамгаалах	4,878	9.17%	1735	12.42%	35.6
Боловсрол	2048	3.85%	977	7.00%	47.7
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1780	3.35%	500	3.58%	28.1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	294	0.55%	98	0.70%	33.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1150	2.16%	244	1.75%	21.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	81	0.15%	33	0.24%	40.7
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	23	0.04%	1	0.01%	4.3


Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Гадаадас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадад ажиллах хүч зуучлах

2024 оны II улирлын байдааар хөдөлмөрийн гэрээгээр гадаадын 102 улсын 15,609 иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэд өмнөх оны мөн үеэс 4,399 буюу 39.2 хувиар, өмнөх улирлаас 7,519 буюу 92.9 хувиар нэмэгджээ. Гэрээгээр ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 14,410 (92.3 хувь) нь эрэгтэйчүүд, 1,199 (7.7 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 35.9 хувь нь Улаанбаатар хотод, 46.6 хувь нь Төвийн бүсэд, 11.7 хувь нь Зүүн бүсэд, 3.5 хувь нь Баруун бүсэд, 2.3 хувь нь Хангайн бүсэд оршин сууж байна.

Мөн хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэдийг иргэншлээр нь авч үзвэл, 11,101 (71.1 хувь) нь Хятад, 1,181 (7.6 хувь) нь Энэтхэг, 605 (3.9 хувь) нь Вьетнам, 423 (2.7 хувь) нь Турк, 328 (2.1 хувь) нь ОХУ, 293 (1.9 хувь) нь Филиппин, 260 (1.7 хувь) нь Өмнөд Солонгос, үлдсэн 1,418 (9.0 хувь) нь бусад улсын иргэн байна.

Зураг 20. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэд, хамгийн их 5 улсаар, дүнд эзлэх хувиар




Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

2024 оны II улирлын байдааар 265 иргэн хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан бөгөөд өмнөх улирлаас 59 буюу 18.2 хувиар буурсан байна.

Гадаадад ажилд зуучлагдсан иргэдийн 190 (71.7 хувь) нь Өмнөд Солонгос, 75 (28.3 хувь) нь Япон улсад зуучлагдсан. Ажилд зуучлагдсан иргэдийн 158 (59.6 хувь) нь эрэгтэйчүүд, 107 (40.4 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажилд зуучлагдсан иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 1.9 хувь нь 20 хүртэлх насны, 16.6 хувь 20-24 насны, 29.8 хувь нь 25-29 насны, 27.5 хувь нь 30-34 насны, 18.5 хувь нь 35-39 насны, үлдсэн 5.7 хувь нь 40, түүнээс дээш насныхан байна.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаадад зуучлагдсан иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, 44.9 хувь нь бакалаврын болон дипломын дээд, 39.3 хувь нь бүрэн дунд, 9.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 6.0 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байна.

Зураг 21. Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэд



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа

Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд ажилгүй иргэн, ажил олоход хүндэрлэгтэй иргэн, ажил олгогч, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2024 онд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн 4 үйл ажиллагаа, 25 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2024 оны II улирлын байдлаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд 19.2 мянган иргэнийг хамруулж, 21.6 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийг үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 48.3 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа, 35.5 хувь нь Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа, 14.2 хувь нь Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 2.0 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан байна.

Зарцуулсан хөрөнгийг үйл ажиллагааны төрлөөр авч үзвэл 81.3 хувь нь Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 10.7 хувь нь Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаа, 6.2 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, 1.8 хувь нь Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Зураг 22. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, сая төгрөг, 2024 оны II улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд 2024 оны II улирлын байдлаар 9,271 иргэн хамрагдаж, 386.7 сая төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн 42.2 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 42.1 хувь нь суурь ур чадварын сургалт, 8.0 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 5.2 хувь нь залуучуудын сургалтын зөвлөгөө, 2.5 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалтад хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 38.5 хувь нь танхимын болон үйлдвэрлэл дээрх сургалт, 27.9 хувь нь суурь ур чадварын сургалт, 19.2 хувь нь аж ахуй эрхлэлтийн сургалт, 9.1 хувь нь эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадварын сургалт, 5.3 хувь нь залуучуудын сургалт, зөвлөгөө зохион байгуулах арга хэмжээнд зарцуулсан байна.

Зураг 23. Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны II улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт 2024 оны II улирлын байдлаар 2,718 иргэн хамрагдаж, 17,584.9 сая төгрөг зарцуулж, 3,028 иргэн ажлын байраар хангагдсан байна.

Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 35.0 хувь нь иргэнд санхүүгийн дэмжлэг, 30.9 хувь нь ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, 22.3 хувь нь малчдыг малжуулах үйл ажиллагаанд, үлдсэн 11.8 хувь бусад арга хэмжээнд хамрагдсан байна. Харин зарцуулсан хөрөнгийн 42.5 хувь нь иргэн, аж ахуй нэгжийн санхүүгийн дэмжлэг, 28.1 хувь нь ахмадад санхүүгийн дэмжлэг, 27.6 хувь нь малчдыг малжуулах арга хэмжээнд зарцуулсан.

Зураг 24. Санхүүгийн дэмжлэг олгох хөтөлбөрт хамрагдсан иргэд, зарцуулсан хөрөнгө, 2024 оны II улирлын байдлаар



Мэдээллийн эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

